



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1999 оны 5 дугаар
сарын 06 өдөр

Дугаар 484

Улаанбаатар
хот

Хүнсний бөөний худалдааны
төв ажиллуулах зөвшөөрөл
олгох тухай

Нэг. Нийслэлийн Засаг даргын 1997 оны А/258 тоот захирамжаар баталсан
“Хүнсний бөөний худалдааны төвийн журам”-ын дагуу хүнсний бөөний төв
ажиллуулах зөвшөөрлийг хавсралтанд дурдсан аж ахуйн нэгжүүдэд олгосугай.

Хоёр. Дээрх хүнсний бөөний төвүүдэд орчны тохижилт, ариун цэвэр, эмх
цэгц, дэг журмыг зохих шаардлагын дагуу хангах талаар холбогдох гэрээ
байгуулан ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нар, Захирагчийн ажлын албаны
Хот тохижилтын хэлтэс /Г.Өлзий/-т үүрэг болгосугай.


Гурав. Энэ захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Улаанбаатар
хотын Захирагчийн ажлын алба /Э.Гомбожав/-нд даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ



М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 1999 оны
4.28 тоот захирамжийн хавсралт

ХҮНСНИЙ БӨӨНИЙ ХУДАЛДААНЫ ТӨВ АЖИЛЛУУЛАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Чингэлтэй дүүрэг

1. Хаян ХХК-ний хүнсний бөөний төв -Чингэлтэй дүүрэг. 5 дугаар хороо, Баруун сэлбэ үйлчилгээний төвийн ард
2. Миёка ХХК-ний хүнсний бөөний төв -Баянгол дүүрэг. 6 дугаар хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 3 дугаар байранд

Хоёр. Хан-уул дүүрэг

1. "Элкс трейд" ХХК-ний хүнсний бөөний төв -Хан-уул дүүрэг. 3 дугаар хороо, Чингэсийн өргөн чөлөө, 18 дугаар сургуулийн урд

Гурав. Баянзүрх дүүрэг

1. "Эн-ба" ХХК-ний хүнсний бөөний төв -Баянзүрх дүүрэг. 16 дугаар хороо, Дандарбаатарын гудамжинд
2. "Блэк морган" ХХК-ний хүнсний бөөний төв -Баянзүрх дүүрэг. 6 дугаар хороо, Арслантай гүүр ХХК-ний хажууд.

Дөрөв. Сонгинохайрхан дүүрэг

1. "Макс импэкс" ХХК-ний хүнсний бөөний төв -Сонгинохайрхан дүүрэг. 1 дүгээр хороолол, 2-р үйлчилгээний төвд